

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмсүгэй:

**1/12.7 дугаар зүйл:**

**“12.7 дугаар зүйл. Бэлгийн дарамт учруулах**

1. Хохиргчийн хүсэл зоригийн эсрэг бэлгийн харьцаанд орох, бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийх сэдлээ үг хэлээр, биеэр, бусад хэлбэрээр байнга илэрхийлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас дөрвөн зуун наян цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг хохирогчийн ажил олгогч, удирдах албан тушаалтан, сурган хүмүүжүүлэгч үйлдсэн бол нийтийн албанад ажиллах эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасаж дөрвөн зуун наян цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Энэ гэмт хэргийн хохирогч нь бэлгийн халдашгүй байдал нь зөрчигдсөн аль ч хүйсийн хүн байж болно.”

**2/13.13 дугаар зүйл:**

**“13.13 дугаар зүйл. Албадан хөдөлмөрлүүлэх**

1. Бусдад хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, эсхүл хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр булийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж хүсэл зоригийн эсрэг, эсхүл цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

**Тайлбар: Албадан хөдөлмөрт хугацаат цэргийн алба, шүүхийн шийтгэх тогтоолыг үндэслэн гүйцэтгүүлж буй нийтэд тустай ажил хамаарахгүй.”**

### **3/15.7,15.8 дугаар зүйл:**

#### **“15.7 дугаар зүйл.Эмнэл зүйн туршилтад оруулах**

1.Хүн, эсхүл хүүхэд, сэтгэцийн өвчний улмаас эрх зүйн чадамжгүй болох нь тогтоогдсон өвчтөний хууль ёсны төлөөлөгч /эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-ээс нь бичгээр зөвшөөрөл авахгүйгээр анагаах ухааны эмнэл зүйн туршилтад оролцуулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

#### **15.8 дугаар зүйл.Шаардлага хангагүй, зөвшөөрөлгүй бэлдмэл хэрэглэх**

1.Дархлаажуулалт, эсхүл сэргийлэх тарилга хийхдээ шаардлага хангагүй, эсхүл зөвшөөрөлгүй бэлдмэл хэрэглэсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

### **4/16.10 дугаар зүйл**

#### **“16.10 дугаар зүйл.Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх**

1.Хүүхдийн оюун ухаан, биеийн хөгжил, амь нас, эрүүл мэндэд аюул учруулах, хүмүүжил, ёс суртахуунд сөргөөр нөлөөлөх хориглосон ажил, үйлчилгээ эрхлүүлсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

### **5/19.18 дугаар зүйл:**

#### **“19.18 дугаар зүйл.Монгол Улсын хилийн зурваст хориглосон зүйл ажиллагаа явуулах**

1.Хилийн зурваст зөвшөөрөлгүйгээр барилга байгууламж барьсан, газрын хэвлийд халдсан, улсын хил хамгаалах байгууллагад урьдчилан мэдэгдэхгүйгээр тэсэлгээ хийсэн бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

### **6/20.18 дугаар зүйл:**

**“20.18 дугаар зүйл.Шаардлага хангаагүй барилгын материал,  
түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдах, түгээх**

1.Шаардлага хангаагүй барилгын материал, түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн, худалдсан, түгээсэн, импортлосны улмаас үлэмж хэмжээний хохирол, эсхүл хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан, эсхүл хүний амь нас хохирсон бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон, эсхүл энэ гэмт хэргийн улмаас хоёр, түүнээс олон хүний амь нас хохирсон бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

5.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.”

**2 дугаар зүйл.**Эрүүгийн хуулийн 20.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “нэвтрүүлсэн” гэсний дараа “, түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах журам зөрчсөн” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Эрүүгийн хуулийн дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/19.14 дүгээр зүйл:**

**“19.14 дүгээр зүйл.Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх**

1.Монгол Улсад орох, гарах хил нэвтрэх эрхийн баримт бичиггүйгээр, эсхүл хуурамч баримт бичгээр, эсхүл зохих зөвшөөрөлгүйгээр Монгол Улсын хилийг биечлэн нэвтэрсэн, эсхүл нисгэгчгүй төхөөрөмж, зориуд сургаж бэлтгэсэн мал, амьтан улсын хил нэвтрүүлсэн бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.бүлэглэж;

2.2.улсын хилийг газрын хэвллийгээр нэвтэрсэн;

2.3.хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: -Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэн гарсан Монгол Улсын иргэн хэргээ илчлэн ирсэн бол ялаас чөлөөлж болно.

-Үзэл бодол, улс төрийн, шударга ёсны бусад үйл ажиллагааны улмаас хавчигдан мөшгигдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад орогох эрх олж авахын тулд Монгол Улсын хил нэвтэрсэн бол энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй.

-Хүн худалдаалах, хүн хулгайлах гэмт хэргийн хохирогч болсон хүн баримт бичиггүйгээр, хуурамч баримт бичгээр Монгол Улсын хил нэвтэрсэн бол энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй.”

## **2/20.12 дугаар зүйл:**

### **“20.12 дугаар зүйл.Эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдах, түгээх**

1.Эрүүл ахуйн шаардлага хангаагүй, хүний эрүүл мэндэд хохирол учруулж болох хүнсний, эсхүл хүнсний нэмэлт бүтээгдэхүүн зориуд үйлдвэрлэсэн, худалдсан, түгээсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

## **2.Энэ гэмт хэргийн улмаас:**

2.1.хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учирсан;

2.2.үлэмж хэмжээний хохирол учирсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж арван мянган нэгжээс наян мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

4.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ. “

**4 дүгээр зүйл.**Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “зургаан сараас” гэснийг “нэг сараас” гэж, 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “эсхүл зургаан

сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих ” гэж, 17.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих ” гэснийг “эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих ” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл, 17.4 дүгээр зүйлийн тайлбарыг хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.** Энэ хуулийг Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын хөгжлийн банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### “31 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

31.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ..... дүгээр  
...сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “31.3, 31.4-т” гэснийг “22.3, 22.4 -т” гэж, мөн зүйлийн 17.4.4 дэх заалтын “31.3-т” гэснийг “22.3-т” гэж тус тус өөрчилсүгэй.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ..... дүгээр  
...сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төрийн албаны тухай хуулийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.1.6 дахь заалт нэмсүгэй:

“22.1.6.Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлсэн байх.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ..... дүгээр  
... сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай өөрчлөн найруулсугай:

“14.1.7.Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ИРГЭНИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Иргэний хуулийн 369 дүгээр зүйлийн 369.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“369.1.Хөдөлмөрийн гэрээгээр ажилтан нь ажил олгогчоос оноосон ажил үүргийг ажил олгогчийн удирдлага, заавар, хяналтан доор биечлэн гүйцэтгэх, ажил олгогч цалин хөлс олгох, хөдөлмөр эрхлэлтийн бусад нөхцөлөөр хангах үүргийг тус тус хүлээнэ. Талуудын хооронд үүссэн харилцаа нь хөдөлмөр эрхлэлтийн харилцааны шинжтэй бол байгуулсан гэрээний нэршил, хэлбэрээс үл хамааран талуудын хооронд хөдөлмөрийн гэрээ байгуулагдсанд тооцно. Тухайн харилцаа нь хөдөлмөр эрхлэлтийн харилцааны шинжийг агуулсан эсэхийг тогтооход харилцааны бүх нөхцөл байдлыг харгалзаж үзнэ.”

**2 дугаар зүйл.** Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 32.5.6 дахь заалтын дугаарыг “32.5.3” гэж өөрчилж, доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“32.5.3.хөдөлмөрийн гэрээгээр ажилтанд төлөх цалин, олговор, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, татварын албаны тодорхойлолтоор баталгаажсан татвар, шимтгэлийн өр болон хөдөлмөрийн болон хамтын гэрээгээр хүлээсэн бусад өр төлбөр;”

**3 дугаар зүйл.** Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 32.5.3, 32.5.4, 32.5.5, 32.5.6 дахь заалтын дугаарыг “32.5.4, 32.5.5, 32.5.6” гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.** Иргэний хуулийн 363 дугаар зүйлийн 363.1 дэх хэсгийн “Ажиллуулагч нь” гэснийг “Хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол ажиллуулагч нь” гэж өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Энэ хуулийг Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хучин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ..... дүгээр  
...сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 12 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 12.8 дахь хэсэг нэмсүгэй:

“12.8.Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй нь тусгай зөвшөөрөл олгох, сунгахгүй байх үндэслэл болно.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ..... дүгээр  
...сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.5 дахь хэсэг нэмсүгэй:

“15.5. Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн үнэмлэх олгох, сунгах, сэргээх, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн хийх, тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, оношлогоонд оруулахыг хориглоно.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ..... дүгээр  
...сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 17.10 дах хэсэг нэмсүгэй:

“17.10. Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь эрх бүхий этгээдээс оногдуулсан торгох шийтгэлийг хуульд заасан хугацаанд биелүүлээгүй бол үндэсний гадаад паспорт олгохыг түдгэлзүүлнэ.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ..... дүгээр  
...сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “3 өдрийн” гэснийг “1 өдрийн” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” гэснийг “Зохиогчийн эрхийн тухай” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” гэснийг “Зохиогчийн эрхийн тухай” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НОМЫН САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Номын сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” гэснийг “Зохиогчийн эрхийн тухай” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1 дэх заалтын “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” гэснийг “Зохиогчийн эрхийн тухай” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МУЗЕЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Музейн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” гэснийг “Зохиогчийн эрхийн тухай” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Гаалийн тухай хуулийн 262 дугаар зүйлийн 262.1 дэх хэсгийн “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” гэснийг “Зохиогчийн эрхийн тухай” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6 дахь хэсгийн “Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” гэснийг “Зохиогчийн эрхийн тухай” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ..... дүгээр  
...сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Автотээврийн тухай хуулийн 10 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 10.2.12 дах заалт нэмсүгэй:

“10.2.12. Нийтийн тээврийн хэрэгсэлд дүрс бичлэгийн техник хэрэгсэл байршуулсан байх.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ..... дүгээр  
...сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Татварын ерөнхий хуулийн 82 дугаар зүйлийн 82.1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 82.1.3 дахь заалт, тайлбар нэмсүгэй:

“82.1.3. Татварыг хуулиар тогтоосон хугацаанд нь төлөөгүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд төлөгдөөгүй татварын 0.1 хувиар.

Тайлбар: Энэ зүйлийн 82.1.3 дахь заалтад заасан торгох шийтгэлийн хэмжээ нь төлөх татварын хэмжээний 10 хувиас хэтрэхгүй байна.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ..... дүгээр  
...сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай тухай хуульд 35 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 35.1.17 дахь заалт нэмсүгэй:

“35.1.17.Гэрийн тэжээвэр амьтан, эсхүл мэргэжлийн үйл ажиллагааны зүйл болдог бусад амьтан тэжээх журам, суурьшлийн бусэд тэжээхийг хориглох амьтны жагсаалт батлах.”

**2 дугаар зүйл.**Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35.1.17 дахь заалтын дугаарыг “35.1.18.” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ..... дүгээр  
...сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Банкны тухай хуулийн 48 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий хэсэг, заалт нэмсүгэй:

1/48 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 48.1.18, 48.1.19 дэх заалт

“48.1.18. Төлбөр, тооцооны баримтыг нуун дарагдуулсан, эсхүл харилцагчийн төлбөр, тооцоог саатуулсан бол хүнд таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийн, хуулийн этгээдэд тавин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийн мөнгөн албадлага оногдуулна.

48.1.19. Тайлан, тэнцэл, аливаа мэдээ баримт, банкийг тогтвортжуулах төлөвлөгөөг Монголбанканд зохих журам, шийдвэрийн дагуу гаргаж өгөөгүй, ирүүлээгүй, тайлан мэдээг буруу тайлагнасан, хугацаа хоцроосон, эсхүл нийтэд мэдээлбэл зохих санхүүгийн тайлан, бусад мэдээллийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр нийтэд мэдээлээгүй бол хүнд хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийн, хуулийн этгээдэд хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийн мөнгөн албадлага оногдуулна.

48.1.20. Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд зааснаас бусад байдлаар банкны тухай хууль тогтоомжийг зөрчсөн бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийн, хуулийн этгээдэд зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийн мөнгөн албадлага оногдуулна.

2/48 дугаар зүйлийн 48.5 дахь хэсэг:

“48.5. Энэ зүйлд заасан мөнгөн албадлагын төлбөрийг Төрийн сангийн холбогдох дансанд шилжүүлэх бөгөөд мөнгөн албадлагын нэг нэгж нь Зөрчлийн тухай хуульд заасан торгуулийн нэг нэгжтэй тэнцүү байна.”

**2 дугаар зүйл.** Банкны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсгийн “энэ зүйлд” гэснийг “энэ зүйлийн 48.1.1- 48.1.17-д” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрднө.

Гарын үсэг

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны ..... дүгээр  
...сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 4.1.10 дахь заалт нэмсүгэй:

“4.1.10. Энэ хуулийн 4.1.1, 4.1.2-т зааснаас бусад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд, Монголбанкнаас зөвшөөрөл авсан оператор.”

**2 дугаар зүйл.** Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 19.1 дэх хэсгийн “4.1.1 гэсний дараа “, 4.1.10” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2022 оны ..... дүгээр  
...сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Хууль хэрэгжүүлэх зарим  
арга хэмжээний тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТӨГТООХ нь:

1. Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Зөрчил шалган шийдвэрлэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-д дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай:

1. Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудыг сургалтад хамруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;

2. Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Гарын үсэг